ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр Дугаар А/57 Өвт

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.18, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрийн Жугам хороололд иргэн Гүрсэдийн Маамхүүгийн эзэмшиж буй 6221001841 нэгж талбарын дугаартай, 1061 м^2 талбай бүхий гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар нь бусдын өмчилсөн газартай давхацсан тул газар эзэмших эрхийг хүчингүйд тооцсугай.

2. Газар эзэмших эрх, эрхийн гэрчилгээг нь хүчингүй болгосон талаар иргэнд мэдэгдэж, холбогдох гэрээ, гэрчилгээг хууль журмын дагуу цуцлахыг Газрын даамал (И.Маралмаа)-д даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын "Газар эзэмшүүлэх тухай" 2015 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн А/19 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

6222011 9
D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/